

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-18

1. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан	5-16
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	16-17
3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулах тухай/	17-18

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Ганзориг, Х.Ганхуяг;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Д.Батлут, П.Мөнхтулга;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Х.Болормаа,
Ж.Ганбаатар, Б.Түвшин, Б.Чойжилсүрэн.

Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Ц.Бархас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, З.Мэндсайхан, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад тайлангийн хурлыг даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, нэр дэвшигч Ц.Бархас нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Цолмонгийн Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Цолмонгийн Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарыг дэмжсэнээр тооцож, 61.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Р.Батболд, Д.Батлут, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар нар орж ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдавааг дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Г.Ганбаатар, Г.Дамдинням нар орж ажиллахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 45 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 11 цаг 21 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Хуралд ирэх ёстой 25 гишүүнээс одоогийн байдлаар 13 гишүүн ирж, хуралдааны ирц 52 хувьтай байна.

Тийм учраас 2025 оны нэгдүгээр сарын 22-ны өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдааны үйл ажиллагаа нээснийг мэдэгдье ээ. Бүртгүүлсэн гишүүдийг би танилцуулъя.

Норовын Алтанхуяг гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Ринчендоржийн Батболд гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Загджавын Мэндсайхан гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн нар гишүүн бүртгүүлсэн байна.

Бүртгүүлсэн гишүүд хуралдааныхаа танхимд орж ирье. Зарим нь байхгүй байна.

Ингээд та бүхэнд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Эхний асуудал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан сонсоно.

Хоёр дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Үндэсний аудитын газрын геологи судалгааны тайланд хийсэнтэй холбогдуулаад шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсэг байгаа.

Гуравт мөн Байнгын хорооны тогтоолын ажлын хэсэг байгуулах нөгөө Оюу Толгойн тайлантай холбогдолтой. Ийм 3 асуудал байна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу, алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцэж эхэлье ээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүнийг Төсвийн байнгын хороо санал болгон дэвшүүлэхтэй холбогдуулан 2024 оны 1 сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Та бүхэнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг тараасан байгаа. Сонсголын тайланг сонсгол даргалагч Дамдинням гишүүн танилцуулна. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Цолмонгийн Бархастай хийсэн нэр дэвшигчийн сонсголын тайлангаа танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус бус гишүүнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо нэр дэвшүүлж Улсын Их Хурал томилохоор заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1 дэх заалтад Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаар томилгооны сонсголыг санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-өөс 133 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30, 31 дүгээр зүйл, Нийтийн сонсголын тухай хуульд заасан үндэслэл, журам, дэгийг баримтлан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус албан тушаалд нэр дэвшигчээс томилгооны сонсголыг Төсвийн байнгын хороо дараах үе шаттайгаар зохион байгууллаа.

1.Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвших хүсэлтийг Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт загварын дагуу ирүүлэхээр мэдээллийн хэрэгслүүдээр нээлттэй мэдээлэн 2024 оны 12 дугаар сарын 26-наас 30 ны өдрийн 17 цаг хүртэл хугацаанд цахимаар болон бичгээр хүлээн авсан. Энэ хугацаанд хуульд заасан шаардлагыг 4 нэр дэвшигч хүсэлт материалаа ирүүлж бүртгүүлсэн.

2.Төсвийн байнгын хорооны 2025 оны нэгдүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.6 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигч бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар иргэн Ц.Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжсэн.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчтэй томилгооны сонсгол явуулахаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны нэгдүгээр сарын 7-ны өдрийн нэгдүгээр тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр явуулахаар товлож Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямьг сонсгол дарлагчаар сонгосон бөгөөд 2025 оны нэгдүгээр сарын 7-20-ны өдөр буюу 14 хоногийн хугацаанд нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигчийн талаар бичгээр гаргах оролцогчийн саналыг хүлээн авахаар parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж мэдээлсэн.

Энэ хугацаанд сонсголд оролцох хүсэлт болон нэр дэвшигчийн талаар бичгээр санал гаргаагүй болно.

4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 33 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 10 цагт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсгол явуулж хуралдаанд Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул хүчинтэйд тооцон сонсголыг явууллаа.

5.Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 132 дугаар зүйлд заасан дэгийг баримтлан сонсгол даргалагч нэр дэвшигчийн талаар товч танилцуулж, үүний дараа нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлагыг тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа танилцуулж дууссаны дараа Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх дэгээр явуулсан болно.

5.1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигч Цолмонгийн Бархас. Нэр дэвшигч нь нэр дэвших хүсэлтдээ санхүүгийн зах зээл, тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогч тэгш боломж олгох замаар санхүүгийн зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн инновац, технологийг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлэх талаар тусгасан байна аа. Нэр дэвшигч Ц.Бархасаас Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт болон санхүүгийн зах зээлийн шударга өрсөлдөөн бүрдүүлэхэд талуудын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэхтэй холбоотой хяналт зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдсон тохиолдолд ХК Хөрөнгийн биржтэй хамтран ажиллахад үүсдэг хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд баримталж болох зорилтын талаар асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Г.Дамдинням нар нэр дэвшигчид хандаж үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд ХК-ийн төлөөллүүд томилогдож шийдвэр гаргах ажиллагаанд оролцох нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж харагдахуйц нөхцөл байдал үүсэж байгаа болон банк бус санхүүгийн байгууллагуудаас олгож байгаа хэрэглээний зээлийг хязгаарлаж бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням санхүүгийн зах зээлд бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг нээлттэй мэдээлэхэд санаачилга гаргаж ажиллах, ББСБ-д ажиллагсдын буруутай үйл ажиллагааны улмаас зээлжих зэрэглэлийн ангилалд буурсан чийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих асуудалд анхаарч ажиллах талаар үг хэлсэн.

6.Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь:

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу мөн өдрийн 12

цагт сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасан.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцүүлж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүнд баярлалаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайлантай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Сонсгол даргалагчаас нэр дэвшигчээс асууж болно. Цогтбаатар гишүүн асуух юм уу? Нэрээ өгье, нэрээ өгье. Гараа өргөөд суугаад байх юм та хэд маань. Булгаа кноп оо.

Булгантуяа гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуултаа асууна.

Да.Цогтбаатар: Төсвийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Сонсголын тайлантай холбоотойгоор асуух асуулт байгаа. Энэ гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг мэдээллийн хэрэгслүүд дээр нээлттэй мэдээлнэ гээд байгаа. Энийг ямар мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж зарласан бэ гэдгийг нэг асуух асуулт байна.

Тэгээд энэ 14 хоногийн хугацаанд нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаар бичгээр гаргах оролцогчийн саналыг хүлээн авахаар parliament.mn гэдэг сайтаар юм шиг байгаа юм. Тэгээд энэ сайт дээр ерөөсөө санал ирээгүй юм уу эсвэл энэ сайт ажилладаггүй юм уу гэдгийг нэг асуух гэсэн юм.

Тэгээд энэ Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигч Бархас чинь өөрөө ашиг сонирхолтой байж болохуйц хүн байна шүү. Өмнө нь Монголбанкны хяналтын зөвлөл мөнгөний бодлого Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны болон орон тооны бус гишүүнд яг энэ ард санхүүгийн нэгдэлтэй холбоотой ХК банк бусуудад удирдлагаар ажиллаж байсан хүмүүс томилогдсон.

Тэгэхээр чинь энэ ингээд ашиг сонирхлын зөрчил өмнөх хүмүүс дээр нь яг мэргэжлийн дагуу ажиллаж байна болж байна гээд дэмжээд явуулсан. Одоо бол ингээд бөөн бөөнөөрөө нэг байгууллага руу Байнгын хороо болгоноос нэр дэвшиж орж ирж байгаа нь зөрчил болох уу гэдгийг асуух гэсэн юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүн сонсгол даргалагч хариулъя.

Г.Дамдинням: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Өчигдөр бид бүхэн хуралдаад хэлэлцсэн тайлангийн тухай асууж байна. Тэгээд тайлан дээр бол би энэ тайлангийн төслийг та бүгдэд тараачихсан байгаа. Энэ дээр 3 дахь заалт дээр нь би түрүүн хэлсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130, 131.1, 131.2 тэгээд Хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 2 дахь заалтуудыг үндэслээд бид нар Дэгийн тухай хуулиараа юу юм билээ parliament.mn дээрээ л албан ёсоор мэдээлэх хуулийн заалттай. Тэндээс нь олон нийтийн хэвлэл мэдээллийнхэн аваад цааш нь тавина.

Тэгээд энийгээ 14 хоногийн хугацаанд бол тэнд байршуулах дэгтэй. Тэгээд тэрүүгээрээ явсан.

Хоёрдугаарт бол хэрвээ нэр дэвшигчтэй холбоотой асуулт хариулт одоо энэ бол олон нийт үзэж байгаа учраас нэг зүйлийг хэлчихмээр байгаа юм. Ер нь томилгооны сонсголууд дээр бол явахад Улсын Их Хурлын гишүүдээс гадна бусад хүмүүс сонсголд оролцож асуулт асуух, хариулт авах эрхтэй. Тийм хүмүүс бол бүртгүүлээгүй. Дараа нь бичгээр хүсэлт гаргаж асуулт асуух эрхтэй. Ер нь ард иргэд бүгдээрээ нийтээрээ.

Тэр зарчмын дагуу ч гэсэн асуулт хариулт ирээгүй. Тэгэхээр бас дараа дараачийн сонсголууд дээр олон нийт бас энэ дээр оролцох энэ боломж нь нээлттэй байдаг юм байна лээ шүү.

Ц.Даваасүрэн: 2 дахь нь ашиг сонирхлын зөрчилтэй байсан уу гэж байна. Монголбанкны хяналтын зөвлөл юу юу гэсэн бэ тиймээ тэрэнд нь хариулъя.

Г.Дамдинням: Одоогийн байдлаар бол хууль тогтоомжийнхоо хүрээнд одоо манай энэ сонсгол зохион байгуулах ажил дээр ямар нэг байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн ямар нэг тийм дүгнэлт бол хаа нэг газраас ирээгүй. Энэ дээр бол гишүүд нээлттэй асуулт асууж өөрөөс нь тодруулах ийм боломж нь бол дэгийнхээ хуулиар нээлттэй байгаа байх.

Ц.Даваасүрэн: Тийм. Тодруулах юм уу айн? Хуулиараа тийм юм байна тиймээ. Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

З.Мэндсайхан: Санхүүгийн зохицуулах хорооноос ерөнхийдөө явуулж байгаа үйл ажиллагаа маань нэлээн тийм хариуцлагатай үйл ажиллагаануудыг ер нь зүгээр юу гэдэг юм Банкны зах зээлийн салбарын орхигдуулчихсан байгаа талбар дээр жишээлбэл одоо банк бус санхүүгийн байгууллагууд гарч ирээд энэ дээр үйл ажиллагаа явуулж байгаа энийг зохицуулах, ХК-удын ялангуяа бага хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг гээд энэ бүхэн дээр та бүгдийн үүрэг роль өндөр байгаа хариуцлагын асуудал. Тэгээд гишүүд ч гэсэн энийг их яриад байгаа юм аа. Би бол өөрийг чинь танихгүй юм. Зүгээр ашиг сонирхлын зөрчил гэдэг зүйлийг та өөрөө юу гэж хараад байна аа? Мэдээж одоо энэ чиглэлийн байгууллагууд дээр ажилласан туршлага чинь өнөөдөр өөрийг чинь энэ байгууллагад нэр дэвших энэ боломжийг бүрдүүлж өгсөн байх гэж бодож байна. Ажлын туршлага чинь. Гэхдээ цаашдаа та бүгд маань жишээлбэл та Үнэт цаасны компанид тийм банканд гээд ингээд ажиллаж байсан. Энэ эрх ашгийн зөрчлүүдийг үйл ажиллагаанд явуулахдаа та хэрхэн зохицуулж явах вэ? Энэ хувь хүний л асуудал, ёс суртахууны асуудал болж хувирах байх.

Нөгөө талдаа өнөөдөр энэ нэг зээлийн аппликэйшнүүд гээд нэг зүйл гараад ирчихсэн байна л даа. Нэг шууд зээл авчихдаг. Тийм ямар ч барьцаагүй аваад. Эндээс явж явж энэ цикл чинь иргэдийг маш их тийм санхүүгийн дарамт өрөнд оруулах ийм л хүндрэлтэй байдал руу оруулах гээд байгаа юм. Юу вэ гэхээр зэрэг зээл аваад явж байгаад сарын дараа хугацаа нь болоод төлж чадахгүй болохоор нөгөө аппликэйшнээс нь аваад ч юм уу ингээд ямар нэгэн тэр хэрэгт зээл авч байгаа хүнд тавьж байгаа шалгуур нь маш бага сул болчихсон. Ингээд явж байгаад эцсийн дүндээ нөгөө муу иргэн маань сая төгрөгийн зээлтэй байсан бол тэр нь зээлийн

төлөлт нь байнга өсөж явах ийм боломжууд гараад ирж байна аа. Ийм эрсдэлүүд гарч ирж байна.

Тэгэхээр энэ дээр та бүгд та юу гэж харах вэ. Энэ чиглэлээр та бүгд маань цаашдаа энэ хороон дээр ороод сонгочихсон тохиолдолд анхаарч ажиллах шаардлагатай шүү гэдгийг хэлэх байна. Ингээд би саяын асуултууддаа танаас нэг хариулт авчихъя гэж бодож байна.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч хариулна. 4 номерын микрофон.

Ц.Бархас: Сайн байцгаана уу эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Эрх ашиг гэдэг асуулт дээр би түрүүлээд хариулъя гэж бодож байна. Ажилд ороод би өнгөрсөн хугацаанд нийтдээ Монголын 4 томоохон групп компанид ажиллаж байсан. Одоогоор бол энэ 4 компанид би ямар нэгэн хувь хувьцаа алинд нь ч хувь хувьцаа эзэмшдэг ямар нэгэн тийм зүйл байхгүй. Энэ 4 компанд дөрвүүлэнд нь би яг л нөгөө энгийн хөлсний ажилтан шиг, хөлсний гүйцэтгэх захирал шиг цалингаа аваад тэгээд хариуцсан ажлаа хариуцлагатайгаар бол хийгээд ингээд явж байсан. Түрүүний хэлж байсан ашиг сонирхолтой байж магадгүй гээд хэлж байсан компанид би анх орсон түүх нь гэх юм бол 2020 онд зохион байгуулагдсан Апрентис гээд нэвтрүүлэгт би тодорхой хэмжээнд амжилттай оролцоод ажиллах урилгаар шагнуулаад ингээд ажилд анх орсон байдаг. Яг тэр ажлаа бол би жил гарны өмнө хүлээлгэж өгөөд одоо бол би худалдааны компанид гүйцэтгэх захирлын ажил ингээд хийгээд ажиллаж байгаа.

Одоогоор бол надад ямар нэгэн хувь хувьцаа байдаг юм уу, мөнгө санхүү эс үгүй бол өөр ямар нэгэн эрх ашиг ямар нэгэн холбоо хамаарал байхгүй. Би тусдаа өөрийнхөө хариуцсан ажлыг хийгээд явж байгаа. Энэ ажилд миний нэр дэвшсэн зорилго бол яах вэ яг энэ салбарт би ажиллаж байсан. Хөрөнгө оруулагчдаа энгийн жижиг хөрөнгө оруулагч болон хөрөнгө босгож байгаа аль аль талдаа би яг талбар дээр нь тулж өөрөө ажиллаж байсан хүний хувьд бол бас өөрийнхөө хувь нэмрийг оруулах ийм боломжтой юм байна гэж өөрөө өөртөө шийдсэний үндсэн дээр энэ ажлын байран дээр би өргөдлөө ингээд хүсэлтээ бол өгсөн байгаад байгаа. Эрх ашиг гэдэг зүйл дээр бол би өчигдөр сонсгол дээр хэлж байсан. Ерөнхийдөө ямар ч өнгөрсөн хугацаанд ажиллаж байсан бүх л ажил дээрээ би эрх ашиг гэхээс илүүтэй гол суурь зарчим байх ёстой гэж би ойлгодог.

Аливаа юмны суурь нь зөв байх ёстой.

Тэгэхээр суурь зарчим маань хэрвээ зарчмаа бариад явах юм бол ямар ч зүйлийн үр дүн нь бол зөв болдог гэж боддог учраас би бол эрх ашиг биш зарчим бол нэгдүгээрт байдаг аа. Тэгэхээр миний хувьд бол өнгөрсөн ажлууд дээрээ зарчмаа бариад л ажилладаг байсан. Тийм учраас тодорхой хэмжээнд Монголын томоохон компаниуд хариуцлага итгэл хүлээлгээд ингээд хариуцлагатай ажлуудыг надаар хийлгэж байсан байх. Зарчим гэдэг зүйл бол мэдээж нэг хүнд нэг л өдрийн дотор бий болдог зүйл биш. Өнгөрсөн бүх ажлууд дээрээ би яг л нөгөө зөв байх ёстой энэ ажил өөрөө зөв явах ёстой гэдэг энэ л зарчмыг барьдаг байсан учраас ч одоо ч гэсэн яг тэрүүгээрээ л би явж байгаа.

Цаашдаа ч гэсэн хийх ажлуудаа яг л тэр зарчмынхаа дагуу би хийгээд явна гэж бодож байна.

Тийм зээлийн асуудал дээр өчигдөр сонсгол дээр давхар хэлж байсан. Яалт ч үгүй хөрөнгийн санхүүжилтийн өртөг өөрөө маш өндөр байгаа. Жишээ нь намайг Үнэт цаасны компани дээр ажиллаж байхад үйлдвэрлэл эрхэлдэг бизнес хийдэг айлууд ингээд хөрөнгө босгуулах гэсэн юм гээд хөрөнгийн зах зээл дээр гээд ороод ирдэг. Тэгэнгүүт дундаж нэрлэсэн хүү нь өөрөө хөрөнгийн зах зээл дээрээс жишээ нь хаалттай бонд босоход 20 хувь байгаа. Энэ дээр бонд босгохтой холбоотой бусад нэмэлт зардлуудаа төлөөд явахаар нөгөө бизнесийн байгууллагад ойролцоогоор 25 хувийн хүүтэй нэгхэн жилийн хугацаатай санхүүжилт босгох боломж байгаа юм. Тэгээд ямар ч үйлдвэрлэл эрхэлж байгаа айл нэгхэн жилийн хугацаатай 25 хувийн хүүтэй санхүүжилт босгочоод тэрүүгээрээ бизнес хийнэ гэвэл өөрөө боломжгүй.

Тэгэхээр яг одоогийн энэ эдийн засгийн өгөгдөл дээр ямар зүйл боломжтой байгаа вэ гэхээр 25 хувийн хүүтэй санхүүжилт өртөгтэй санхүүжилт босгочоод, буцаагаад нөгөөдхөө 30 юм уу, 35 хувийн хүүтэй жижиглэн зээл болгож гаргах гаргах ганцхан л нөгөө зах зээлийн боломж нь байгаа учраас одоо ингээд харахаар IPO хийж байгаа айлууд байдаг юм уу, хаалттай бонд босгож байгаа айлууд дандаа л дийлэнхдээ санхүүгийн зах зээлтэй холбоотой айлууд болж таараад байгаа юм. Гишүүд бас мэдээлэлтэй байгаа байх. Сүүлийн 10 гаруй жил ингээд харахаар өрхийн дундаж зардал бол дандаа л орлогоо давсан байдаг. Тэгэхээр яалт ч үгүй нөгөө буцаагаад л банкнаас зээл авдаг. Банкнаас зээл авах шаардлагыг нь хангахгүй байгаа айлууд нь бол жижиг аппликэйшнийхаа зээлүүд рүү ордог. Тэгэхээр энэ бол буцаад нөгөө эдийн засгийнхаа бүүр илүү суурь асуудлууд руу орох байх аа. Яаж нөгөө амьжиргааны түвшнийг дээшлүүлэх вэ хүмүүсийнхээ өрхийнхөө орлогыг нэмэгдүүлэх вэ гэдэг рүүгээ орох байх гэж бодож байна.

Ц.Даваасүрэн: Болсон уу мэндсайхан гишүүн. Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Хөрөнгийн бирж санхүүгийн зах зээл уг нь тухайн улс орны яг эдийн засгийн халууны шил шиг байдаг. Төсвийн алдагдал энэ тэрийг бол тооцоход бүтэн нэг жилийн дараагаар дээрээс нь нэмээд бүүр статистик тоон мэдээллийг хүлээх юм бол бараг дараа оных нь 6 сараас гардаг. Санхүүгийн зах зээл бол бараг өдөр тутамд дэлхийн зах зээл дээр болж байгаа мэдээтэй уялдаад байнга савлаж байдаг. Монголын санхүүгийн зах зээл Трамп анх удаа сонгогдоход өмнө нь Ерөнхийлөгчөөр сонгогдоход дэлхийн бүх санхүүгийн зах зээл дээр хөрөнгийн бирж дээр уналт үүсэхэд ганцхан Монголын санхүүгийн зах зээл дээр ямар ч юм өөрчлөлт мэдэгдээгүй байна гээд тухайн үед экономист сэтгүүл дээр бүүр гарч байсан. Өөрөөр хэлбэл манай санхүүгийн зах зээл хорвоо дэлхийгээс тийм их хол, хэнтэй ч холбогддоггүй, ямар ч мэдээлэлд бараг өртдөггүй Монголын хэдхэн компаниуд. Тэгээд тэд нь голдуу үнэнийг хэлэхэд нэг гэр бүлийн эзэмшлийн компаниуд байдаг өөрөө сайн мэдэж байгаа. Бараг худалч хүнд нөгөө эзэд нь салж бай гэвэл манай санхүүгийн зах зээл дээр салж бай нийлж бай дотроо хэрүүл үүсэж бай гэвэл манай санхүүгийн зах зээл савлах байх.

Тийм их хорвоо дэлхийгээс тасарчихсан бид нар хөрөнгийн биржтэй, санхүүгийн зах зээлтэй байна гэсэн үг шүү. Тэгээд энүүнийг бид нар нэг бодолцохгүй бол одоогоор нэг дуалестэд компани ганцхан байгаа тиймээ ганцхан байгаа. Тэгээд тэрүүнийгээ миний мэдэж байгаагаар сүүлийн хэдэн жил том амжилт гээд л ярьсаар байгаад л төдийгөөс өдий болсон. Тэгээд үүн дээрээ нэгдүгээрт анхаараарай.

Хоёрдугаарт бас Төсвийн байнгын хорооны дарга эрхэм гишүүддээ бас хэлэхэд манай нөгөө хөрөнгийн зах зээл, Санхүүгийн зохицуулах хороо маань ганцхан дереватив үнэт цаас, бондоос гадна маш олон юмыг зохицуулдаг болсон. Тэгээд энэ удаа орон тооны бус гишүүд болон хяналтын зөвлөлийн гишүүдийг харахад бусад салбарын хүмүүс ерөөсөө орж ирэхгүй байгаад байна аа. Одоо тэрнээс гадна Койны биржүүдийг зохицуулалт хийдэг болсон хуулиараа. Үл хөдлөх хөрөнгө дээр бараг санхүүгийн зах зээл дээр эргэлдэж байгаа мөнгө шиг их хэмжээний мөнгө үл хөдлөх хөрөнгө дээр эргэлдээд энд хууль бус мөнгө эргэлдээд байна уу, үгүй байна уу гээд ФАТФ-ын зөвлөмжийн дагуу бас үүн дээр Санхүүгийн зохицуулах хорооноос ажилладаг болсон. Үнэт эдлэл дээр бас ажилладаг болсон. Ломбард дээр бас ажилладаг болсон, хяналт тавьдаг болсон.

Тэгээд яг энэ чиглэлийн нарийссан мэргэшсэн хүмүүс маань жоохон дутуу дулимаг яг энэ орон тооны бус гишүүд дээр болон хяналтын зөвлөлийн гишүүд дээр жоохон дутуу дулимаг ажиллаад байна уу даа гэж харагдаж байна аа. Тэгээд энүүн дээр бас таны туршлага энэ бүгд дээр яая гэж бодож байна аа? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт одоо энэ санхүүгийн зах зээлтэй холбоотойгоороо та өөрөө ажиллахгүй байгаа гэж бид нар ойлгож байгаа зөв үү? Яагаад гэвэл нөгөө талдаа орон тооны бус гишүүнээр ажиллачхаад яг энэ салбар дотроо зохицуулалт хийж байгаа салбар дотроо та өөрөө ажиллаж орлого олж болохгүй шүү дээ тийм ээ. Өөрөөсөө гаргасан шийдвэрээсээ үүдээд тэгэхээр энэ нь өөрөө бол давхар энэ салбарт ажиллаж орлого олохгүй байгаа гэж ойлгож байгаа зөв үү?

Дээрээс нь нэмээд энэ койнтой холбоотой ямар зохицуулалтуудыг та бүхэн хийе гэж энэ орон тооны бус гишүүний хувьд ямар бодлого барья гэж бодож байна вэ гэдэг нэг ийм хэдэн асуулт.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч хариулъя. 4 номерын микрофон.

Ц.Бархас: Гишүүний 2 дахь асуултаас нь би хариулъя гэж бодож байна. Тийм таны Булгантуяа гишүүний хэлж байгаа зөв. Яг одоогоор би олон улсын худалдааны компанид ажиллаж байгаа. Яг гаднаас томоохон брэндүүдийн бүтээгдэхүүнийг онцгой эрхтэйгээр гэрээ байгуулаад наашаа Монгол руугаа оруулж ирээд ингээд худалдааны бизнес л гэсэн үг олон улсын худалдааны. Энэ бизнесийг хариуцаад би жил гаруй яг болж байна. Тэгэхээр бол Санхүүгийн зохицуулах хорооны яг зохицуулдаг салбарын ямар нэгэн компанитай бол ажиллаж байгаа ямар нэгэн холбоо хамаарал бол байхгүй ээ. Эхний таны хэлдэг саналтай бол би санал нийлж байна. Аль л олон жилийн өмнөөс л хөрөнгийн зах зээл дүлий л байсан. Компани нь аягүй сайн ашигтай ажиллаад байдаг, хувьцааных нь үнэ тэрэнд нь ямар ч нөгөө илэрхийлэмж байдаггүй. Дэлхий нийтээр янз янзын том том мэдээнүүд эс үгүй бол тухайн компанийн үйл ажиллагаа нь болохгүй байна гээд байдаг бас л нөгөө дүлий хэвээрээ л байгаад байдаг.

Энэ бол миний харж байгаагаар дундаж хөрөнгө оруулагч юу вэ гэхээр дундаж цалин бол 2 сая төгрөгтэй л байгаа. Тэгэхээр дундаж хөрөнгө оруулагч 1 сая 500-аас 2 сая төгрөгтэй хүн өдрийнхөө идэж ууж байгаагаас өөрөөсөө харамлаад 200, 300 мянган төгрөгөөр хадгалж байгаа. Тэрийгээ буцаагаад хөрөнгө оруулна гэхээр урт хугацааны хөрөнгө оруулалт хийх ямар ч боломжгүй. Жижиг хөрөнгө оруулагч. Тэгээд яаж хөрөнгө оруулж байгаа вэ гэхээр хэн нэгэн мэддэг хүнээс дийлэнх хөрөнгө оруулагч жижиг хөрөнгө оруулагч яг ийм л замаар явж байгаа. Хэн

нэгэн найзаасаа юм уу хэн нэгэн мэддэг гэж боддог хүнээсээ асуудаг. Одоо нэг ийм IPO болох гэж байгаа юм байна. Хувьцаа нь өсөх юм болов уу? Надад нэг 500 мянган төгрөг байгаа юм. Бид тэрийгээ хийчих үү, зөв үү буруу юу? Тэгээд нөгөө жоохон шуум авчихсан хувьцаа нь бол ингээд шуураад очоод өсчхөөд. Тэр чинь нөгөө урт хугацааны хуримтлал, урт хугацааны хөрөнгө оруулалт биш учраас богинохон хугацааны тэрэн дээрээ өгөөж хөрөнгө оруулалт жижиг хөрөнгө оруулагч маань хараад буцаагаад гараад явчихдаг. Энэнээс цаашаа бол зах зээл бол яг л нөгөө анх ямар байсан яг тэр хэв нь дээ л ингээд байж байдаг. Тэгээд энэ зүйл дээр бол нөгөө урт хугацааны хөрөнгө оруулалтын институцүүд урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжтой энэ байгууллагуудыг бол ихээр бий болгох тоглох боломжийг нь бий болгох, дээрээс нь нөгөө мэргэжлийн хөрөнгө оруулагчид энэ дээр, зах зээл дээр илүү сайн оролцож байж өөрөө зах зээл маань багтаамж нь ахиад томорч байж энэ зах зээл маань бол хөгжих юм л гэж харах гээд байгаа юм.

Өөрөөр хэлбэл нөгөө эрэлт бага байгаад байгаа учраас зах зээл маань бол сайн ч мэдээ болсон, муу ч мэдээ болсон нөгөөдхөө сонсдоггүй дүлий чигээрээ ингээд байгаад байдаг аа. Би таны саналтай бол санал нийлж байна. Гурав дахь асуулт дээр яалт ч үгүй энэ бол нөгөө зохицуулалт хэрэгтэ одоо салбар гэвэл тийм. Энэ дээр бол дэлхий нийтийн хандлага явж байгаа. Тэгэхээр энэ хандлага дээр бол мэдээж Монгол хоцорч болохгүй. Гэхдээ энэ дээр хөрөнгө оруулагчид болон ямар нэгэн хүмүүсийн эд хөрөнгө бол хохирох ёсгүй учраас энэ дээр бол зөв зохицуулалтууд бол шаардлагатай гэж үзэж байна.

Ц.Даваасүрэн: Болсон уу Булгантуяа гишүүн ээ? Нэр дэвшигчээс би зүгээр нэг зүйл тодруулъя.

Энэ санхүүгийн зах зээл дээр байгаа далд эдийн засгийн гол эх үүсвэр бол хар мөнгө л байгаа шүү дээ. Ер нь тэр авлигалын аль эсвэл мөнгө угаалтын ийм мөнгөнүүд байгаа. Тэгээд Монголд өнөөдөр энэ авлигал гэдэг юм байгаад байгаагийн нэг үндэслэл бол бэлэн төлбөр тооцоо байгаа байхгүй юу. Бэлнээр хийгээд байна шүү дээ. Валютын зах зээл дээр бэлнээр явж байна. Тэгээд энэ бэлэн мөнгөний төлбөр тооцооны асуудлыг хязгаарлах чиглэл дээр ер нь ямар бодолтой байдаг вэ? Ямар саналтай байдаг вэ? Нэр дэвшигч 4 номерын микрофон.

Ц.Бархас: Таны асуултад хариулъя. Би бол нөгөө чөлөөт эдийн засагт итгэдэг. Тэгэхээр ямар нэгэн байдлаар нөгөө хүчээр ямар нэгэн журмаар энийг бэлэн мөнгийг хязгаарлах дүрэм журам гаргах нь бол би учир дутагдалтай буруу гэж бодож байна. Харин ямар шийдэл байх вэ гэхээр эргүүлээд нөгөө иргэдийнхээ эдийн засгийн санхүүгийн мэдлэг боловсрол руу илүү чиглэсэн тэр ажлуудаа л илүү түлхүү сайн хийх ёстой. Ингэж байж нөгөө илүү шат ахиж дараагийн зөв хувилбар луугаа орно гэж бодож байна. Тэрнээс энийг бол дүрэм журмаар биш илүү нөгөө боловсрол илүү мэдлэг нэмэх замаар бол шийдэх боломжтой гэж харж байна.

Ц.Даваасүрэн: Энэ их бэлэн мөнгө эргэлдээд байгаа улсууд чинь дийлэнх нь боловсролтой л байгаа л даа. Энэ чинь ард түмэн биш байхгүй юу. Энэ чинь цөөхөн хэдхэн хэмжээнд нийтдээ энэ чинь нийт хадгаламжийн 90 хувь нь гуравхан хувьд байгаад байна шүү дээ хүн амын. Тэгээд энэ чинь тийм олон хүнийг хамарсан асуудал биш. Дийлэнх нь боловсролтой байгаа. Тэгээд ёс зүйтэй холбоотой асуудал. Тэгэхдээ энийг зах зээл зохицуулна гэдэг юм уу ингээд чөлөөтэй байдлаар ингээд хаячхаж болохгүй. Яагаад гэвэл шунал гэдэг бол ёс зүйтэй шууд холбоотой байдаг учраас шунал нь ёс зүйгээ идэж байдаг учраас энийг төр зохицуулахгүй

болдоггүй ийм эд ээ. Тийм учраас өнөөдрийн энэ цахим ертөнцөд бэлэн төлбөр тооцоо явж байна гэдэг бол бүдүүлэг зүйл. Бэлнээр төлбөр тооцоо хийж байгаа тохиолдолд татвар ч хянаж чадахгүй. Энийг санхүүгийн зах зээл дээр бид нар тодорхойлж чадахгүй.

Тийм учраас бэлэн бус төлбөр тооцоог хязгаарласны дараа бол бид нар хэн ямар орлого олж байна хэн ямар мөнгө эргэлдүүлж байна гэдэг нь бүгд тодорхой болно. Татварын алба нь ч хялбар болно. Тэгж байж бид нар энэ санхүүгийн зах зээлийг цэвэр тунгалаг болгоно уу гэхээс биш хар мөнгө бэлнээр эргэлдэж байгаа тохиолдолд хяналт тавьж чадахгүй. Тэрийг ёс зүйгээр арилгана гэвэл тэр худлаа. Шуналыг ёс зүй давдаггүй. Шунал гэдэг бол ёс зүйг идэж байдаг эд байхгүй юу. Тийм учраас энэ дээр жаахан анхааралтай хандаж байх ёстой. Сонсголтой холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу? Санал байна уу?

Ганбаатар гишүүн нэрээ өгчих, Мөнхсоёл гишүүнийг орууллаа. Та 2-ын хэн нь эхлэх юм? Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Хоёрт нь хэлье гэсэн түрүүлээд гарчихлаа. Өчигдөр сонсгол болсон өнөөдөр ингээд үргэлжилж байна. Тэгээд миний бодлоор бусад нөгөө гишүүд нь Эдийн засгийн байнгын хороогоор ороод чуулганаар батлагдаад гарчихсан. Тэгээд яг энэ Монгол шиг бас жижигхэн улсад компаниас яг энэ төлөөлөл орохгүй байх ёстой гэсэн шалгуур нь өөрөө учир дутагдалтай гэж бодож байна. Бас туршлага хэрэгтэй шүү дээ. Тал талын оролцогчдыг төлөөлсөн ийм бүтэц байх ёстой гэж бодож байна. Тэгээд хүмүүсийн асууж байгаа зүйл нь энэнтэй илүү холбоотой ашиг сонирхлын зөрчлийн талаар зориуд асууцгааж байгаа байх. Би ч гэсэн асуусан юм өчигдөр. Тэгээд хэрэвзээ сонгогдоод гараад ирэх юм бол өөрийнхөө ярьсан тэр зарчим дээр үндэслээд тиймээ ёс суртахуунтайгаар санхүүгийн зах зээл дээр орж ирж оролцож байгаа тэр хүмүүст янз бүрийн давуу эрх мэдэл, давуу мэдээлэлтэй байгаагаа ашиглан шийдвэр гарахгүйгээр маш их тийм ил тоод засаглалыг сайжруулах чиглэлээр ажиллаарай гээд амжилт хүсье ээ.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн үг хэлье.

Г.Ганбаатар: Тэгээд хэрвээ сонгогдвол 2 зүйл дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Нэгдүгээрт нь иргэдийн энэ санхүүгийн боловсролыг сайжруулах чиглэлээр тэр Санхүүгийн зохицуулах хорооноос нэлээн ажил хиймээр байгаа юм. Ер нь одоо энэ манай өнөөгийн хөрөнгөжсөн жоохон баяжсан л гэж ярих юм уу даа. Хөрөнгөжсөн улсууд чинь ихэвчлэн 2 янзаар баяжсан байдаг юм.

Нэгдүгээрт нь социализмын үеийн уул уурхай бэлэн хайгуулыг тухайн үед ажил албан тушаал эрх мэдээллийнхээ давуу талыг ашиглаад уул уурхай руу ороод нэг хэсэг нь нэлээн хөрөнгөжсөн байх шиг байгаа юм. Нөгөө хэсэг нь нөгөө нэг зах зээлийн үед нөгөө цагаан, ягаан тасалбар, цэнхэр ягаан тасалбар байх үед иргэдийн санхүүгийн мэдлэг дутуу байх үед тэр тасалбаруудыг нь хямдаар аваад тэгээд одоо болтол зарим нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчөөд яваад байгаа зүйл харагдаад байдаг юм.

Тийм учраас иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах чиглэлээр сайн ажиллаарай гэж нэгдүгээрт нь.

Хоёр дахь зүйл нь болохоор манай энэ Монгол залуучууд энэ хар тамхи мөрийтэй тоглоомд үнэхээр энэ ажил амьдралаа их сүйтгэж байгаа харагдах юм.

Маш олон залуучууд саяхан бас тэр сошиал орчинд нэг жүжигчин 800 сая төгрөгөөрөө яачихлаа ч гэнэ үү юм яриад л байгаа юм. Тэгэхээр энэ цахим тоглоом, мөрийтэй тоглоом, цахим тоглоом ялангуяа тэр нөгөө X bet билүү энийг яаралтай цэгцлэхгүй бол энэ залуучууд нэг жаал олсон зовж олсон мөнгөө ер нь тэгээд цахим тоглоом, хар тамхи хоёрт үрээд дууслаа. Тийм учраас энэ цахим тоглоомыг сайн цэгцлээрэй гэж хүсэх байна аа. Энэ 2 зүйлийг л хэлэх байна даа. Баярлалаа. Амжилт хүсье.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигчийн сонсголын тайлантай холбогдуулж гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Ингээд санал хураалт явуулна. Пүрэвдаваа гишүүн орж ирэхгүй юм байх даа. Санал хураалтыг байна шүү дээ нууцаар явуулах юм. Хүрнэ хүрнэ, үгүй яах вэ зүгээр бүрэн ирцтэй. Нөгөө ирээгүй улсуудынх чинь эсрэгээр гарна шүү дээ. Тэгээд би тэгээд байхгүй юу. Харин тийм 13-аас тэгээд бүртгүүлчихсэн улсыг би дуудаад байхгүй юу. Одоо жишээлбэл Пүрэвдаваа, Батболд гишүүн энэ тэр орж ирэхгүй болохоор яах вэ эсрэг гарна. Болох юм уу?

Ингээд нэр дэвшигч Цолмон овогтой Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Мөнхсоёл гишүүн горимын саналаа хэлье.

Б.Мөнхсоёл: Худал ярих ямар хэрэг байна өөрөө өгчихмөөр байх юм дэмжиж байгаа хүнээ. Ямар ч ашиггүй байхгүй юу. Энэ төхөөрөмж дээр саналаа оруулж ерөөсөө амжсангүй. Горимын санал гаргалаа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Төхөөрөмжийн алдаа гарсан учраас дахин санал хураалт явуулж өгөөч гэж байна тийм үү? Энийг нэг удаа л явуулна шүү гишүүд анхааралтай байгаарай.

Саяын тийм Мөнхсоёл гишүүний санал хураалтыг дахин явуулж өгөөч гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Энэ төхөөрөмжийн алдаа гарсан учраас болохгүй. Сая бол нэлээн хэдэн хүний төхөөрөмжийн төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр ингэе минийх ч болсонгүй. Дахин санал хураалт явуулъя. Тэгэхийн тулд сая төхөөрөмж. Төхөөрөмжүүд минийх, Дамдинням гишүүнийх, Булгантуяа гишүүнийх байсан уу, чинийх өөр хаана байсан бэ айн? Заяабал. Энэ төхөөрөмжүүд алдаатай ажилласан учраас дахиад санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 13-аас 8 гишүүн оролцож, санал хураалтыг дахин явуулъя гэсэн горимын санал дэмжигдлээ.

Одоо гишүүд анхааралтай. Одоо бол дахихгүй шүү. Бас хариуцлагатай санал хураалт явж байгаа учраас Мөнхсоёл гишүүний горимын санал дэмжигдсэн учраас

Цолмон овогтой Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёолтыг дахин явуулъя.

Ингээд 13-аас 6 гишүүн дэмжээд 46.2 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Хэнийх орсонгүй вэ? Заяабал гишүүнийх ороогүй юм уу?

Ингээд санал хураалт 13 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 46.2-оор уг санал дэмжигдсэнгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Дамдинням танилцуулна аа.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа.

11.58 цагт

Дараагийн асуудалдаа оръё. [Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.](#)

Төсвийн байнгын хорооны 2025 оны 1 сарын 14-ний өдрийн хуралдаанаар Үндэсний аудитын газраас ирүүлсэн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх геологи судалгааны ажлын тайланг хэлэлцсэн. Тайланг хэлэлцээд тодорхой асуудлууд дээр шийдвэр гаргая гэсэн санал гарсан. Тухайлбал Заяабал гишүүнээс авхуулаад нэлээн хэдэн гишүүн ийм санал хэлсэн учраас тайлантай холбогдуулаад шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулъя гэж ингэж шийдсэн байгаа. Ингээд би та бүхэнд энэ ажлын хэсэг байгуулах тухай шийдвэрийн төслийг тараасан байгаа.

Ажлын хэсэг байгуулах тухай гээд.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь.

Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологи судалгааны ажлын хэрэгжилт үр дүнгийн дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан аудитын шалгалтад хамрагдсан. Энэ дээр санал хураалт байгаа юу. Зарим нэг улсуудыг дуудчихмаар байх юм. Төрийн тогтолцоо, чиг үүрэг, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалт, геологи, судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Заяабал Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ж.Баясгалан Монгол Улсын Их Хурлын гишүүн, Г.Ганбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Г.Дамдинням Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжилтнийг шинжээчдийг татан оролцуулах болон ажлын хэсгийн тайлан, холбогдох санал, дүгнэлтээ 2025 оны хаврын чуулганы хугацаанд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Ийм ажлын хэсэг байгуулъя. Байнгын хорооны энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулт, үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

Тэгвэл тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй учраас санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

13 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж 53.8 хувиар уг санал дэмжигдлээ. Цогтбаатар гишүүн дэмжсэнээр протоколд авъя аа.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

12.02 цагт

Гурав дахь асуудалдаа оръё. Мөн [Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.](#)

Төсвийн байнгын хорооны 2025 оны нэгдүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Үндэсний аудитын газраас ирүүлсэн Оюу Толгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс тайланг нээлттэйгээр хэлэлцэж мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийг хангах мөн дээрх асуудлаар холбогдох санал, дүгнэлт шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэсэн саналууд гарсан.

Үүний дагуу аудитын тайланг нээлттэй ирүүлэх талаар албан тоотыг Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн. Мөн энэ хугацаанд ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлагатай гэж үзэж ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь.

1.Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Үндэсний аудитын газрын Оюу Толгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж байгаатай холбогдуулан санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Д.Батлут, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Б.Мэндсайхан Монгол Улсын Их Хурлын гишүүн, Дав.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Р.Батболд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Н.Алтанхуяг Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн шинжээчдийг татан оролцуулах болон ажлын хэсгийн тайлан, холбогдох санал, дүгнэлтээ 2025 оны хаврын чуулганы хуралдаан Төсвийн байнгын хорооны хуралдааны танилцуулгыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Ийм тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй учраас Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ажлын хэсэгт орох гишүүдийн нэрийг авъя. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүнийг нэмье гэж байгаа юм байна тиймээ орж болж байна.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг шийдвэрлэлээ. Оруулчихъя. Батболд гишүүн орчихсон байсан юм байна. Пүрэвдаваа гишүүн орлоо. Өөр гишүүн алга байна шүү дээ тийм үү? Ингээд эдгээр гишүүдээр ажлын хэсэг байгуулахаар шийд тогтлоо. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ. Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

12.05 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА